

## ДҮРМИЙН ТӨСӨЛД САНАЛ АВАХ.

1. [ИИД-65 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл](#); дүрмийн нэмэлт өөрчлөлт

### 2. ИИД-91 “Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм”-д оруулах нэмэлтийн талаар

1/ Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас “Цахилгаантай үүлийг ямар зайд тойрч нисэх, мөн хоёр цахилгаантай үүлний хоорондын зай хэдэн км байх үед дундуур нь нисэн өнгөрч болох талаар” ИИД-91-д тусгахыг хүсэж ИИИИ-11/01 маягтын дагуу өргөдөл гаргасан болно.

2/ Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын газрын холбогдох байцаагч, мэргэжилтнүүд өргөдөлд дурьдсан асуудлыг судалж үзээд ИИД-91-ийн “Нислэгийн ерөнхий дүрэм” гэсэн “В” Бүлэгт “*Цахилгаанжилттай ба аадар хур тундастай бүсэд нислэг үйлдэх*” тухай 91.257-р зүйлийг шинээр нэмэхээр төлөвлөж байна. Үүнд:

#### *91.257. Цахилгаанжилттай ба аадар хур тундастай бүсэд нислэг үйлдэх*

(а) Газрын радарын хяналтгүй, цахилгааны голомтыг ажиглах радарын хэрэгсэлгүй агаарын хөлгөөр аадар, хур тунадастай, цахилгаанжилттай бүсэд хэрэглэлээр нислэг үйлдэхийг хориглоно.

(б) Нислэгийн удирдагч нь цаг уураас өгсөн зөвлөгөө, радарын мэдээлэл зэргийг үндэслэн үүл цахилгаанжилтын байдал, тэдгээрийн шилжилт, цахилгаантай бүсийг хэрхэн тойрч гарах талаар нисгэх багт зөвлөгөө өгнө. Газрын радараар ажиглалт хийх боломжгүй үед нисгэх баг аадар, хур тундсыг хөлгийн радараар болон ил хараагаар тойрон гарна.

3. [ИИД-101 Хүнгүй нислэг тэрэг болон автожир-үйл ажиллагаа](#); -д оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар 2014.10.28- 11 дүгээр сарын 28 хүртэл

Санал авах хугацаа: 2014.10.15-наас 11 дүгээр сарын 15

Санал ирүүлэх хаяг: [n](#) This e-mail address is being protected from spam bots, you need JavaScript enabled to view it

Холбоо барих: 28-5035, 28-5026